



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/132

Мандалговь

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2003 оны 105 дугаар зарлиг, Монгол Улсын "Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай" хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5-ын /а/, "Монгол хэлний тухай" хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, Аймгийн ИТХТ-ийн 2014 оны 265 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын зөвлөлийн 2018 оны 04 дүгээр сарын 06-ны өдрийн 05 дугаар хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. "Үндэсний бичиг" аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд жил бүр уламжлал болгон зохион явуулдаг "Үндэсний бичиг үсгийн баяр"-ын үйл ажиллагаанд санхүүгийн дэмжлэг үзүүлсүгэй.

Хоёр. Уралдааны шагналын зардлыг хавсралтаар баталсугай.

Гурав. Дээрх уралдааныг зохион байгуулахад шаардагдах 765,000 /долоон зуун жаран таван мянга/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гарган зарцуулахыг аймгийн ЗДТГ-ын дарга /Ц.Эрдэнэсүрэн/, нягтлан бодогч /Г.Мөнхбаясгалан/ нарт зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



О. БАТ-ЭРДЭНЭ

0200456